



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 01 сарын 02 өдөр

Дугаар А/01

Бат-Өлзий сум

Засаг даргын Тамгын газрын бүтэц,
орон тоог батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.4 дэх хэсэг, "Бат-Өлзий сумын Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тоог нэмэгдүүлэх тухай" 2023 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн А/760 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тоог хавсралтаар шинэчлэн баталсугай.

2.Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхийг нягтлан бологч (Ч.Батдулам)-д үүрэг болгосугай.

3.Энэ тушаал гарсантай холбогдуулан 2022 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн "Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тоог батлах тухай" А/01 дүгээр тушаалыг хүчингүйд тооцсугай.

ДАРГА

Н.БАТ-ЭРДЭНЭ

Засаг даргын Тамгын газрын даргын
2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн
401 дугаар тушаалын хавсралт

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН БҮТЭЦ, ОРОН ТОО

№	Албан тушаалын нэр	Тоо хэмжээ
1	2	3
1.	Засаг дарга	1
2.	Засаг даргын орлогч	1
3.	Засаг даргын Тамгын газрын дарга	1
4.	Байгаль орчны хяналтын улсын байцаагч	1
5.	Сумын төсвийн ерөнхий нягтлан бодогч	1
6.	Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн	1
7.	Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн	1
8.	Нийгмийн бодлогын мэргэжилтэн	1
9.	Хүнс, жижиг дунд үйлдвэр, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн	1
10.	Мал аж ахуйн үйлдвэрлэлийн төлөвлөлт, менежмент, малын үржил, бүртгэлийн асуудал хариуцсан мэргэжилтэн	1
11.	Бэлчээр, газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтэн	1
12.	Багийн Засаг дарга	6
13.	Нягтлан бодогч	2
14.	Архив, бичиг хэргийн эрхлэгч	1
15.	Нийгмийн ажилтан	1
16.	Нярав	1
17.	Жолооч	1
18.	Үйлчлэгч	1
Нийт дүн		24